

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ I ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01

Зуунмод

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны үйл ажиллагааны
тайлан, 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, аудитын
ажлын төлөвлөгөө батлах тухай

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан тухай Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Б.Саруулын мэдээллийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын 2021 оны төлөвлөгөөний дагуу 15 сумын 94-н төсөвт байгууллага, ТЭЗ-ын харьяа аймгийн төвийн 11-н төсөвт байгууллага, 2- ОНӨҮГ, 3-н ТӨХК, бусад ТЭЗ-ийн харьяа 9 байгууллага, нийт 119 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийхээс, 3 байгууллага /Авто тээврийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын газар харьяа ТЭЗ-ын шалгалт давхардсан учир хийгдээгүй / хасагдаж, үлдсэн 116 байгууллага бүгд хамрагдсан. Ковид-19 өвчний хөл хорионы улмаас төлөвлөгөөт ажил 3,4-р улиралд нилээд шахагдаж Аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн тусгай сангууд, Төв Чандмань ДЭХГ-т санхүүгийн хяналт шалгалтууд он дамжин хийгдэж дуусч байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хувь “ ” үнэлгээтэй ханган ажилласан байна.

Шалгалтад хамрагдсан байгууллагуудын дүнгээр 2,968,908.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс зөрчлийг арилгуулахаар 2,596,864.1 мянган төгрөгийн албан шаардлага өгч, аймгийн төсөвт төвлөрүүлэхээр 295,093.2 мянган төгрөг, тухайн байгууллагад нь барагдуулахаар 76,950.9 мянган төгрөгийн; нийт 372,044.1 мянган төгрөгийн СХШ-ын улсын байцаагчийн төлбөрийн акт тогтоосон байна.

Шалгалтад хамрагдсан 113 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийхэд 25 байгууллага бага, 84 байгууллага дунд, 4 байгууллага их эрсдэлтэй / Татварын хэлтэс, Мөнгөнморьт сумын ЗДТГ, Баянцагаан сумын ЭМТ, Төв-Эрдэнэс ОНӨААТҮГ / дүгнэгдэв.

Тус албаны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 23 төсөвт байгууллага, төрийн өмчит хувьцаат компаний 3, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 1, 13 сумын 78 төсөвт байгууллага, нийт 105 байгууллагын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, 2021 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар их эрсдэлтэй дүгнэгдсэн төсөвт 5 байгууллагад гүйцэтгэлийн аудит хийх, сумдын эргэлтийн эмийн сан, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан зэрэг 80

сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, 2021 оны өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, ковид-19 цар тахлын үед олгосон санхүүжилт, хандив, тусламжийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, зөрчлийг арилгуулж зөвлөн туслаж ажиллахаар тусгагджээ.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1, 7.6, Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 тоот тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Дотоод аудитын хорооны хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.
3. Тус албаны 2022 оны хяналт шалгалт, аудитын ажлын төлөвлөгөөний биелэлтийг ханган санхүүгийн хяналт шалгалтын стандартыг мөрдөн ажиллаж, гарч буй санхүүгийн зөрчлийн судалгааг хийж, хэрэгцээнд тулгуурласан сургалт сурталчилгааны ажлыг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч, эд хариуцагч нарт хийж, үр дүнг тооцон ажиллахыг Санхүүгийн хяналт, аудитын алба /Б.Саруул/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг хорооны гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБААТАР